



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/486

Улаанбаатар хот

Орлоготой оюутан үндэсний хөтөлбөрийг
хэрэгжүүлэх, зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн Удирдах хорооны 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 19/01 тоот тогтоолоор батлагдсан Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 46 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 24 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийн хүрээнд суралцах хугацаанд цагийн ажил эрхлэх боломжийг хангаж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Хуулийн хэлтэс, Үйлдвэрлэлийн хэлтэст хууль эрх зүйн, барилгын инженерийн хөтөлбөрийн төгсөх ангийн 33 оюутныг ажиллуулсугай.

2. Төгсөх ангийн оюутныг ажиллуулахад шаардагдах зардал болох 48,877,026 /дөчин найман сая найман зуун далан долоон мянга хорин зургаан/ төгрөгийг хавсралтаар баталж, зардлыг дээд боловсролын шинэчлэлийн төслөөс санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т зөвшөөрсүгэй.

3. Туслах ажилтнуудтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэн ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /О.Хуягцогт/-т даалгасугай.


САЙД



Е. БААТАРБИЛЭГ

0901521

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2019 оны 08 дүгээр сарын 01
өдрийн 486 дугаар тушаалын хавсралт



ТӨГСӨХ АНГИЙН ОЮУТНЫГ АЖИЛЛУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

(төгрөгөөр)					
№		Оюутны тоо	Хүн сар	Сарын хөлс	Нийт хөлс
1	Төрийн захиргааны удирдлагын газар, Хуулийн хэлтэст дадлагын ажил хийх хууль эрх зүйн хөтөлбөрийн төгсөх ангийн оюутан	23	2	740,561	34,065,806
2	Үйлдвэрлэлийн хэлтэст дадлагын ажил хийх барилгын инженерийн хөтөлбөрийн төгсөх ангийн оюутан	10	2	740,561	14,811,220
				Нийт дүн	48,877,026

-----000-----